



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1/09

Улаанбаатар хот

**Багахангай дүүргийн 2024 оны Газар
зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол
оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг хавсралтаар баталсугай.

2.Дүүргийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотголыг дүүрэг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй нягт уялдуулж, биелэлтийг нь хангах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

3.Төлөвлөгөөний тодотголын дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх талаарх төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайхан)-нд үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ



Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 4/09 дүгээр тогтоолын хавсралт

2024-12-011-8247. Дүүргийн 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тодотгол

10210001: Хүлэмж, дарлага /Хүлэмжийн болон хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэх газар/

№	Сум/Дүүрэг	Баг/Хороо	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ м2	Улирал II-IV
1	Багахангай	2-р хороо	4025637	Улсын чанартай авто замын баруун талд, дүүргийн өндөрлөгийн хойд талд	1607: Хүлэмж, дарлага	50342	+

20616001: Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгох газар

№	Сум/Дүүрэг	Баг/Хороо	Төлөвлөлтийн нэгж талбар	Газрын нэр	Газрын зориулалт	Талбайн хэмжээ м2	Улирал II-IV
1	Багахангай	1-р хороо	4025636	Өндөртолгой, 1-р хорооны байрны хойд талд	2122: Нийтийн үйлчилгээний байгууллага	211	+
2	Багахангай	2-р хороо	4039894	Нуурын гэр хорооллын баруун урд талд	2101: Төрийн захиргааны байгууллага	4941	+
3	Багахангай	1-р хороо	4039895	Саалийн толгой гэр хорооллын зүүн урд талд	2101: Төрийн захиргааны байгууллага	4913	+